



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2021 оны 04 сарын 07-ны
өдрийн 5191 дугаарт бүртгэл.

2021 оны 02 сарын 03 өдөр

Бүтэц 04

Эрхэм

Бэлчээр ашиглалт болон отор нүүдэл
зохицуулах журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “д”, 18.1.2 ын “л” дэх заалт, 18.2 дахь заалт, 22 дугаар зүйлийн 22.1.10 дахь заалт 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 20.2.1, 52 дугаар зүйлийн 52.1, 52.2, 52.4, 52.6 дахь заалтууд, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх заалт “Төсвийн тухай хууль”-ийн 58 дугаар дугаар зүйл 58.4.5, 58.4.6 дахь заалт, Улсын Их Хурлын 2009 оны 39-р тогтоолоор баталсан “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын 3.1.2; 2010 оны 23-р тогтоолоор баталсан “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн 3.4.1, 3.2.4.6, 2015 оны 104 дүгээр тогтоолоор баталсан “Төрөөс хүнс хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-ын 2.1.10, 2.1.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Сумын “Бэлчээр ашиглалт болон отор нүүдэл зохицуулах журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тогтоолыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн бичгийн дарга /Б.Туяасайхан /-д даалгасугай.
4. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд үүрэг болгосугай.

ДАРГА  ГЗОЛБААТАР

